



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 1172

Хараат

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной
энгийн механик аргаар тэмцэх ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.10, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Хүнс, Хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/143 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ний өдрийн А/587 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үлийн цагаан оготной энгийн механик аргаар тэмцэх ажлыг 1, 2, 3, 4 дүгээр багийн нутагт дэвсгэрт 2023 оны 11 дүгээр сарын 09-өөс 14-ны хооронд 5 хоногийн хугацаанд багтаан явуулсугай.

2. Тухайн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, албан байгууллага, иргэдийг оролцуулан гүйцэтгүүлж, бэлчээрт үр дүнтэй ажил зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энгийн механик аргаар тэмцэх арга хэмжээг сумын хэмжээнд удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Н.Батгэрэл (Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Жаргалмаа (1,4 дүгээр багийн Засаг дарга)

Э.Баярмаа (2 дугаар багийн Засаг дарга)

Ц.Ундрахбаяр (3 дугаар багийн Засаг дарга)

М.Доржсүрэн (Тамгын газрын нярав)

Нарийн бичгийн дарга: Б.Мөнхтогтох (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)

4. Энгийн механик аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулахдаа хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр ханган аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллах, үлийн цагаан оготной тэмцэх бэлчээрийн газрын мэдээллийг малчдад

өгч, татан оролцуулах хяналт тавин ажиллахыг хөдөө аж ахуйн мэргэжилтэн, байгаль орчны мэргэжилтэн, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.4 багт ажиллах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

6.Дээрх ажлыг зохион байгуулах төлөвлөгөө батлуулан, шаардлагатай техник хэрэгсэл, бензин шатахууныг хариуцан цаг агаарын саатлаас бусад тохиолдолд ажил саатахгүй байхаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Батгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  А.ӨРДЭНЭСАЙХАН

